

ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Орхон сумын ЗДТГ-ын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ДАА-2024/40/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Дархан-Уул аймаг 2024 он	Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Ш.Мөнхбаяр Утас: 70373089 Цахим хаяг: munkhbayarsh@audit.gov.mn Аудитын менежер: У.Батсүрэн Утас:70373089 Цахим хаяг: batsurenu@audit.gov.mn Ахлах аудитор: С.Батцэцэг Утас:70373089 Цахим хаяг: battsetsegs@audit.gov.mn Аудитор: О.Мягмарсүрэн Утас: 70378845 Цахим хаяг: myagmarsureno@audit.gov.mn
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Нэг. Хараат бус аудиторын дүгнэлт



ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Бурхантын гудамж-1, 14 дугаар баг, Дархан сум,
Дархан-Уул аймаг, 45059,
Утас: 7037-3089, Факс: (976) 7037-3089
Цахим шуудан: darhanuul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2024.02.27 № 65

танай _____ -ны № _____ -т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Орхон сумын ЗДТГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Орхон сумын ЗДТГ нь 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд аймгийн ОНӨГ-ын даргын 2023 оны А/17 дугаар тушаалаар 193,250.9 мянган төгрөгийн хөрөнгийг 137,663.3 мянган төгрөгөөр дахин үнэлж, ашиглах хугацааг шинэчлэн тогтоон данс бүртгэлд тусгасан байна.

Аудитын гол асуудал

Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 241 дүгээр тогтоолоор төрийн албан хаагчдын албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоож, 2023 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс олгож эхэлсэн байна. Мөн Засгийн газрын 2023 оны 52 дугаар тэмдэглэлээр цалингийн сангийн хэмнэлтээс ажилтныг ажлын үр дүнг нь харгалзан үндсэн цалингийн 100 хувиар тооцож урамшуулал олгожээ.

Бусад асуудлын хэсэг

Төсвийн шууд захирагч бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Орхон сумын ЗДТГ-ын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 47 арга хэмжээ төлөвлөж, хэрэгжилтийг 100 хувиар тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

0090?010?

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ш.МӨНХБАЯР

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	111,617,322.00	128,794,984.00
33	АВЛАГА	4,291,125.00	-
33300	Татаас, санхүүжилтийн авлага	4,291,125.00	-
35	БАРАА МАТЕРИАЛ	93,874,797.00	118,536,984.00
35100	Түүхий эд материал	-	140,000.00
35130	Эм боох материал	-	140,000.00
35400	Хангамжийн материал	72,247,297.00	102,434,484.00
35410	Бичиг хэргийн материал	371,760.00	21,278,850.00
35420	Аж ахуйн материал	6,374,300.00	5,612,300.00
35430	Сэлбэг хэрэгсэл	3,105,500.00	-
35440	Түлш, шатах тослох материал	453,683.00	-
35450	Барилгын засварын материал	3,400,000.00	3,400,000.00
35460	Хүнсний материал	1,961,620.00	-
35470	Бусад хангамжийн материал	56,580,434.00	72,143,334.00
35600	Мал амьтад	21,627,500.00	15,962,500.00
36	НӨӨЦИЙН БАРАА	13,451,400.00	10,258,000.00
36300	Тэжээлийн нөөц	13,451,400.00	10,258,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	604,882,770.00	719,670,822.36
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	604,882,770.00	719,670,822.36
39200	Биет хөрөнгө	583,769,193.73	708,418,522.58
39201	Барилга, байгууламж, орон сууц	303,333,347.00	281,798,183.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(39,593,759.39)	(39,108,383.28)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	67,911,800.00	67,911,800.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(64,728,384.59)	(67,911,800.00)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	184,110,329.45	187,748,541.56
39206	Хуримтлагдсан элэгдэл	(63,683,994.24)	(43,178,350.92)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	41,431,850.00	28,850,940.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(31,127,260.31)	(12,700,777.36)
39214	Бусад үндсэн хөрөнгө	391,962,815.00	402,164,246.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(205,847,549.19)	(97,155,876.42)
39300	Биет бус хөрөнгө	21,113,576.27	11,252,299.78
39301	Програм хангамж	9,354,300.00	8,914,300.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(2,339,031.37)	(2,468,000.22)
39303	Бусад биет бус хөрөнгө	25,806,000.00	4,806,000.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	(11,707,692.36)	-
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	716,500,092.00	848,465,806.36
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	2,285,113.00	-
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	2,285,113.00	-
41300	Өглөг	2,285,113.00	-
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	1,286,376.00	-
41360	Бусад өглөг	998,737.00	-
41361	Байгууллагад төлөх өглөг	951,144.00	-
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	47,593.00	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	714,214,979.00	848,465,806.36
51	Засгийн газрын хувь оролцоо	714,214,979.00	848,465,806.36
51100	Засгийн газрын оруулсан капитал	620,239,733.02	620,239,733.02
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	620,239,733.02	620,239,733.02
51200	Хуримтлагдсан үр дүн	(184,090,502.35)	(49,839,674.99)
51210	Өмнөх үеийн үр дүн	(276,768,105.83)	(184,090,502.35)
51220	Тайлант үеийн үр дүн	92,677,603.48	134,250,827.36
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	278,065,748.33	278,065,748.33
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	716,500,092.00	848,465,806.36

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	741,716,326.56	1,213,455,254.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	129,978,126.56	208,040,954.00
120	Нийтлэг татварын бус орлого	129,978,126.56	208,040,954.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	4,895,513.00	5,303,612.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	5,187,112.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4,895,513.00	116,500.00
120009	Бусад орлого	245,000.00	-
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	117,837,613.56	176,379,442.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	7,000,000.00	26,357,900.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	611,738,200.00	1,005,414,300.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	6,400,000.00	42,736,200.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,100,000.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4,300,000.00	42,036,200.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	700,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	605,338,200.00	962,678,100.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	605,338,200.00	962,678,100.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	644,651,756.07	1,052,554,462.86
21	УРСГАЛ ЗАРДАЛ	644,651,756.07	1,052,554,462.86
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	552,420,414.98	968,439,016.17
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	244,060,395.63	463,278,318.67
210101	Үндсэн цалин	164,251,632.78	267,693,252.81
210102	Нэмэгдэл	36,634,952.27	132,636,558.52
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	16,594,627.40
210104	Урамшуулал	17,960,957.00	46,353,879.94
210105	Гэрээт ажлын хөлс	25,212,853.58	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	30,748,032.10	56,261,096.65
210201	Тэтгэврийн даатгал	20,950,985.86	38,778,077.73
210202	Тэтгэмжийн даатгал	2,454,494.94	4,550,886.31
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,029,408.87	3,640,668.59
210204	Ажилгүйдлийн даатгал	498,010.74	844,541.42
210205	Эрүүл мэндийн даатгал	4,815,131.69	8,446,922.60
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	39,096,367.48	38,582,245.05
210301	Гэрэл, цахилгаан	4,452,322.48	4,103,613.05
210302	Түлш, халаалт	34,089,565.00	33,602,792.00
210303	Цэвэр, бохир ус	554,480.00	875,840.00
210304	Байрны түрээс	-	-
2104	Хангамж, бараа материалын зардал	28,780,720.70	35,258,665.94
210401	Бичиг хэрэг	5,785,380.00	2,668,910.00
210402	Тээвэр, шатахуун	8,235,641.00	27,084,883.00

210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,414,449.70	3,100,122.94
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	120,000.00	105,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,388,750.00	2,299,750.00
210408	Бараа материал акталсны зардал	9,836,500.00	-
2105	Нормативт зардал	459,220.00	4,500,000.00
210502	Хоол, хүнс	251,220.00	4,500,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	208,000.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	9,578,400.00	40,987,460.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	-	136,000.00
210604	Урсгал засвар	9,578,400.00	40,851,460.00
2107	Томилолт, зочны зардал	3,159,200.00	5,201,800.00
210702	Дотоод албан томилолт	3,159,200.00	5,201,800.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	117,293,102.00	216,382,558.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	116,677,100.00	215,009,500.00
210803	Даатгалын үйлчилгээ	294,030.00	196,020.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	244,972.00	161,632.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	77,000.00	44,000.00
210807	Газрын төлбөр	-	971,406.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	79,244,977.07	107,986,871.86
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	40,939,335.00	32,686,046.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	870,000.00	90,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	37,435,642.07	75,210,825.86
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	92,231,341.09	84,115,446.69
2132	Бусад урсгал шилжүүлэг	47,705,657.00	20,974,800.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	1,936,000.00	5,285,000.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	7,236,372.00	-
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	31,218,700.00	11,227,800.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	7,314,585.00	4,462,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	44,525,684.09	63,140,646.69
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	44,525,684.09	57,348,656.69
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	-	5,791,990.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	97,064,570.49	160,900,791.14
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	4,386,967.01	26,649,963.78
225001	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз	1,916,967.01	23,901,863.78
225011	Үнэ төлбөргүй гарсан зардал - Бараа материал	2,470,000.00	2,748,100.00
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	92,677,603.48	134,250,827.36

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	627,512,553.00	1,032,389,732.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	5,753,467.00	21,375,742.00
120	Нийтлэг татварын бус орлого	5,753,467.00	21,375,742.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	5,508,467.00	21,375,742.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	7,645,722.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	5,508,467.00	13,730,020.00
120009	Бусад орлого	245,000.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	621,759,086.00	1,011,013,990.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	16,420,886.00	48,335,890.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	4,304,690.00	1,102,700.00
131103	ЗГНХ,ЗДНХхөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,100,000.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4,300,000.00	42,036,200.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	5,716,196.00	5,196,990.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	605,338,200.00	962,678,100.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	605,338,200.00	962,678,100.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	605,801,953.00	994,868,432.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	605,801,953.00	994,868,432.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	506,383,890.91	910,752,985.31
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	242,852,556.33	464,857,894.67
210101	Үндсэн цалин	163,043,793.48	269,272,828.81
210102	Нэмэгдэл	36,634,952.27	132,636,558.52
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	16,594,627.40
210104	Урамшуулал	17,960,957.00	46,353,879.94
210105	Гэрээт ажлын хөлс	25,212,853.58	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	30,748,031.40	56,261,096.65
210201	Тэтгэврийн даатгал	20,950,985.86	38,778,077.73
210202	Тэтгэмжийн даатгал	2,454,494.94	4,550,886.31
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,029,408.87	3,640,668.59
210204	Ажилгүйдлийн даатгал	498,010.04	844,541.42
210205	Эрүүл мэндийн даатгал	4,815,131.69	8,446,922.60
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	39,096,367.48	38,582,245.05
210301	Гэрэл, цахилгаан	4,452,322.48	4,103,613.05
210302	Түлш, халаалт	34,089,565.00	33,602,792.00
210303	Цэвэр, бохир ус	554,480.00	875,840.00
2104	Хангамж, бараа материалын зардал	20,241,582.70	39,881,372.94
210401	Бичиг хэрэг	3,906,880.00	2,780,000.00
210402	Тээвэр, шатахуун	8,683,473.00	26,631,500.00

210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,414,449.70	3,100,122.94
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	120,000.00	105,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,116,780.00	7,264,750.00
2105	Нормативт зардал	208,000.00	4,640,000.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	-	140,000.00
210502	Хоол, хүнс	-	4,500,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	208,000.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	13,167,600.00	39,561,960.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	139,000.00	680,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	-	136,000.00
210604	Урсгал засвар	13,028,600.00	38,745,960.00
2107	Томилолт, зочны зардал	3,159,200.00	5,201,800.00
210702	Дотоод албан томилолт	3,159,200.00	5,201,800.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	122,148,102.00	221,260,270.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	121,532,100.00	219,887,212.00
210803	Даатгалын үйлчилгээ	294,030.00	196,020.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	244,972.00	161,632.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	77,000.00	44,000.00
210807	Газрын төлбөр	-	971,406.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	34,762,451.00	40,506,346.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	33,639,151.00	40,416,346.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,123,300.00	90,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	99,418,062.09	84,115,446.69
2132	Бусад урсгал шилжүүлэг	47,705,657.00	20,974,800.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	1,936,000.00	5,285,000.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	7,236,372.00	-
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	31,218,700.00	11,227,800.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	7,314,585.00	4,462,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	51,712,405.09	63,140,646.69
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	44,525,684.09	57,348,656.69
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	7,186,721.00	5,791,990.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	21,710,600.00	37,521,300.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	21,710,600.00	37,521,300.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	21,710,600.00	37,521,300.00
2200	Дотоод эх үүсвэрээр	21,710,600.00	37,521,300.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	21,710,600.00	37,521,300.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(21,710,600.00)	(37,521,300.00)
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	-	-
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

(төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	620,239,733.02	278,065,748.33	(276,768,105.83)	621,537,375.52
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	620,239,733.02	278,065,748.33	(276,768,105.83)	621,537,375.52
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	-	-	-
C05	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
C06	Тайлант үеийн үр дүн	-	-	92,677,603.48	92,677,603.48
C07	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	620,239,733.02	278,065,748.33	(184,090,502.35)	714,214,979.00
C08	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	620,239,733.02	278,065,748.33	(184,090,502.35)	714,214,979.00
D01	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
D02	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	620,239,733.02	278,065,748.33	(184,090,502.35)	714,214,979.00
D03	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	-	-	-
D04	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-	-	-	-
D05	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
D07	Зарласан ногдол ашиг	-	-	-	-
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	134,250,827.36	134,250,827.36
D09	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	620,239,733.02	278,065,748.33	(49,839,674.99)	848,465,806.36

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

(төгрөгөөр)

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	994,093,100.00	926,705,185.31	(67,387,914.69)	93.22%
21	УРСГАЛ ЗАРДАЛ	994,093,100.00	926,705,185.31	(67,387,914.69)	93.22%
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	970,855,000.00	905,730,385.31	(65,124,614.69)	93.29%
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	484,757,600.00	464,857,894.67	(19,899,705.33)	95.89%
210101	Үндсэн цалин	278,260,200.00	269,272,828.81	(8,987,371.19)	96.77%
210102	Нэмэгдэл	148,765,000.00	132,636,558.52	(16,128,441.48)	89.16%
210103	Унаа хоолны хөнгөлөлт	18,925,500.00	16,594,627.40	(2,330,872.60)	87.68%
210104	Урамшуулал	38,806,900.00	46,353,879.94	7,546,979.94	119.45%
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	60,976,800.00	56,261,096.65	(4,715,703.35)	92.27%
210201	Тэтгэврийн даатгал	41,464,300.00	38,778,077.73	(2,686,222.27)	93.52%
210202	Тэтгэмжийн даатгал	4,878,100.00	4,550,886.31	(327,213.69)	93.29%
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,902,500.00	3,640,668.59	(261,831.41)	93.29%
210204	Ажилгүйдлийн даатгал	975,600.00	844,541.42	(131,058.58)	86.57%
210205	Эрүүл мэндийн даатгал	9,756,300.00	8,446,922.60	(1,309,377.40)	86.58%
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	42,638,900.00	38,582,245.05	(4,056,654.95)	90.49%
210301	Гэрэл, цахилгаан	5,296,600.00	4,103,613.05	(1,192,986.95)	77.48%
210302	Түлш, халаалт	36,100,200.00	33,602,792.00	(2,497,408.00)	93.08%
210303	Цэвэр, бохир ус	1,242,100.00	875,840.00	(366,260.00)	70.51%
2104	Хангамж, бараа материалын зардал	17,791,300.00	17,157,472.94	(633,827.06)	96.44%
210401	Бичиг хэрэг	2,895,500.00	2,516,000.00	(379,500.00)	86.89%
210402	Тээвэр, шатахуун	9,456,600.00	9,456,600.00	-	100.00%
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,084,900.00	3,100,122.94	15,222.94	100.49%
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	120,000.00	105,000.00	(15,000.00)	87.50%
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,234,300.00	1,979,750.00	(254,550.00)	88.61%
2105	Нормативт зардал	1,272,100.00	-	(1,272,100.00)	0.00%
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,272,100.00	-	(1,272,100.00)	0.00%
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	68,812,500.00	67,254,760.00	(1,557,740.00)	97.74%
210601	Багаж, техник, хэрэгсэл	29,200,000.00	28,508,800.00	(691,200.00)	97.63%
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	37,500.00	-	(37,500.00)	0.00%
210604	Урсгал засвар	39,575,000.00	38,745,960.00	(829,040.00)	97.91%
2107	Томилолт, зочны зардал	6,530,300.00	5,201,800.00	(1,328,500.00)	79.66%
210702	Дотоод албан томилолт	6,530,300.00	5,201,800.00	(1,328,500.00)	79.66%
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	239,405,700.00	215,908,770.00	(23,496,930.00)	90.19%
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	236,081,900.00	214,535,712.00	(21,546,188.00)	90.87%
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,945,500.00	-	(1,945,500.00)	0.00%
210803	Даатгалын үйлчилгээ	196,100.00	196,020.00	(80.00)	99.96%
210804	Тээврийн хэрэгслийн татвар	162,200.00	161,632.00	(568.00)	99.65%

210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	44,000.00	44,000.00	-	100.00%
210807	Газрын төлбөр	976,000.00	971,406.00	(4,594.00)	99.53%
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	48,669,800.00	40,506,346.00	(8,163,454.00)	83.23%
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	48,522,000.00	40,416,346.00	(8,105,654.00)	83.29%
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	147,800.00	90,000.00	(57,800.00)	60.89%
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	23,238,100.00	20,974,800.00	(2,263,300.00)	90.26%
2132	Бусад урсгал шилжүүлэг	23,238,100.00	20,974,800.00	(2,263,300.00)	90.26%
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	7,300,000.00	5,285,000.00	(2,015,000.00)	72.40%
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	11,227,800.00	11,227,800.00	-	100.00%
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,710,300.00	4,462,000.00	(248,300.00)	94.73%
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	994,093,100.00	928,665,927.31	(65,427,172.69)	93.42%
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	974,678,100.00	907,290,185.31	(67,387,914.69)	93.09%
320001	Орон нутгийн төсвөөс	974,678,100.00	907,290,185.31	(67,387,914.69)	93.09%
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	19,415,000.00	21,375,742.00	1,960,742.00	110.10%
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	5,493,000.00	7,645,722.00	2,152,722.00	139.19%
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	13,922,000.00	13,730,020.00	(191,980.00)	98.62%
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	43.00	43.00	-	100.00%
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	3.00	3.00	-	100.00%
610001	Төсвийн байгууллага	3.00	3.00	-	100.00%
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	20.00	20.00	-	100.00%
620001	Удирдах ажилтан	5.00	5.00	-	100.00%
620002	Гүйцэтгэх ажилтан	11.00	11.00	-	100.00%
620003	Үйлчлэх ажилтан	3.00	3.00	-	100.00%
620004	Гэрээт ажилтан	1.00	1.00	-	100.00%

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	48,335,890.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	48,335,890.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	42,543,900.00
2104	Хангамж, бараа материалын зардал	22,723,900.00
210401	Бичиг хэрэг	264,000.00
210402	Тээвэр, шатахуун	17,174,900.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,285,000.00
2105	Нормативт зардал	4,640,000.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	140,000.00
210502	Хоол, хүнс	4,500,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7,836,000.00
210601	Багаж, техник хэрэгсэл	7,700,000.00
210603	Хөдөлмөр, хамгааллын хэрэгсэл	136,000.00
2107	Томилолт, зочны зардал	-
210702	Дотоод албан томилолт	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7,344,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	7,344,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	5,791,990.00
2133	Орон нутгийн төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	5,791,990.00
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	5,791,990.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	48,335,890.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	48,335,890.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	1,102,700.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан	42,036,200.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	5,196,900.00

Гурав. Аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 338,645.8 мянган төгрөгийн алдаа¹ илэрснийг аудитын явцад залрууллаа. Үүнд:

1. Үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй бүртгэлд дахин үнэлгээний нэмэгдэл 277,124.5.0 мянган төгрөгийг бүртгээгүй нь УСНББОУС 17 “*Үндсэн хөрөнгө*” болон “*Үнэлгээ ба хуваарилалт*” батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй бүртгэлд холбогдох хөрөнгөд хамаарах дахин үнэлгээний нэмэгдлийг тусгаж залруулав.
2. Санхүүгийн байдлын тайлангийн газар дансанд 24,000.0 мянган төгрөгийн хөрөнгө тусгасан нь УСНББОУС 31 “*Биет бус хөрөнгө*” болон “*Ангилал*” батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул санхүүгийн байдлын тайланд тусгасан хөрөнгийг хасаж залруулав.
3. Мөнгөн гүйлгээний тайланд төсвийн хөрөнгөөр худалдан авсан 37,521.3 мянган төгрөгийг урсгал зардлаар бүртгэсэн нь УСНББОУС 17 “*Үндсэн хөрөнгө*” болон “*Ангилал*” батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул мөнгөн гүйлгээний тайланд биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардалд тусгаж залруулав.

Мөн аудитаар нийт 36,259.8 мянган төгрөгийн зөрчил² илэрсэн тул 2,481.7 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт, 33,008.8 мянган төгрөгийн 2 албан шаардлага, 769.3 мянган төгрөгийн 2 зөвлөмжийг хүргүүллээ.

3.1 Төлбөрийн акт

Аудитаар дараах зөрчилд 2,481.7 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоов. Үүнд:

1. Албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөний 2 дугаар улирлын үр дүнгийн урамшууллыг олгохдоо 2023 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс шинэчлэгдсэн цалингаар тооцож 2,481.7 мянган төгрөгийг илүү олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т “*төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах*”, 16 дугаар зүйлийн 16.5.5-т “*батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах*” гэж заасантай заасантай нийцээгүй бөгөөд санхүүгийн тайлангийн нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй тул төлбөрийн акт тогтоов.

3.2 Албан шаардлага

Аудитаар нийт 33,008.8 мянган төгрөгийн 2 зөрчилд зөрчил арилгах албан шаардлага хүргүүллээ. Үүнд:

1. Гамшгийн эрсдэлийн ерөнхий үнэлгээ хийлгэх 4,500.0 мянган төгрөгийн холбогдох анхан шатны баримтын бүрдэл дутуу, эдийн засгийн ангилал зөрчиж зардал гаргасан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т “*төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах*”, 16 дугаар зүйлийн 16.5.5-т “*батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах*”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д “*Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно*”, 13.7-д “*Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно*” гэж заасантай нийцээгүй бөгөөд санхүүгийн тайлангийн нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй тул зөрчлийг таслан зогсоох, цаашид гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

2. Багаж, техник хэрэгслийн 28,508.8 мянган төгрөгийн худалдан авах ажиллагааг цахим системээр зохион байгуулаагүй, үр дүнг мэдээлээгүй нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.5-д “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зохион байгуулах худалдан авах ажиллагааны сонгон шалгаруулалтыг цахимаар зарлана” гэж заасантай нийцээгүй бөгөөд санхүүгийн тайлангийн нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй тул зөрчлийг таслан зогсоох, цаашид гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

3.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Биет бус хөрөнгөтэй холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Байгууллагын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй газрыг ГХБХБГ-аас авсан лавлагаатай тулган шалгахад 73,000 м.кв талбай бүхий 4 эзэмшлийн газрыг бүртгэлд тусгаагүй байгаа нь Газрын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.2, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.2-т заасантай тус тус нийцэхгүй байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

Газрын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.3-т заасны дагуу санхүүгийн тайланд тусгаагүй 4 газрыг үнэлж, биет бус хөрөнгөөр бүртгэх саналыг холбогдох байгууллагад хүргүүлж шийдвэрлүүлэх.

2. Урсгал зардалтай холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт:

Албан хаагчийн 2022 оны дутуу олгосон цалинг нөхөн олгохдоо 769.3 мянган төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэл, хувь хүний орлогын албан татварыг суутгаж, төсөвт төвлөрүүлээгүй нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 17 дугаар зүйлийн 17.1, Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1, 14 дүгээр зүйлийн 14.1-д заасантай тус тус нийцэхгүй байна.

2.2. Өгсөн зөвлөмж:

Хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлого болон түүнд оногдох шимтгэлийг үнэн зөв тодорхойлж, тогтоосон хугацаанд нийгмийн даатгалын тайланд тусгаж ажиллах, цаашид дээрх алдааг давтан гаргахгүй байх.

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5³-д заасан хугацаанд ирүүлж, биелэлтийг Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

³ Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ.

Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/ сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Орхон сумын ЗДТГ	3	338.6	1	277.1	2	61.5	3	338.6	-	-	-	-
Дүн	3	338.6	1	277.1	2	61.5	3	338.6	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
							Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Орхон сумын ЗДТГ	5	36.3	1	2.5	2	33.0	2	0.8	-	-	-	-
Дүн	5	36.3	1	2.5	2	33.0	2	0.8	-	-	-	-

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1	-	-	1	-	-	-
	НИЙТ	1	1	-	-	1	-	-	-